

АШУУИС, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГУУЛЬ

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЖИЛТАН БАКАЛАВРЫН АНГИ

Хугацаа: 4 жил

Танилцуулга



Монгол улсад 2008 онд батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27-р зүйлд аж ахуйн нэгж байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА) хариуцсан ажилтан ажиллуулахыг хуульчлан заасан.

Сүүлийн жилүүдэд МУ-д үйлдвэржилт нэмэгдэж ажлын байрны аюултай хүчин зүйлсээс шалтгаалсан осол, өвчлөлөөс ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах мэргэжилтний хэрэгцээ өсөн нэмэгдэж байна. Хуулийн шаардлага, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд үндэслэн МУ-д бакалаврын сургалтаар "Хөдөлмөрийн эрүүл ахуйч, аюулгүй байдлын ажилтан" АШУУИС-д бэлтгэж эхэллээ.

Энэхүү сургалтын хөтөлбөрийн зорилго нь "Ажлын байрны аюултай зүйлсийг илрүүлэн таних, хэмжиж үнэлэх, тэдгээрийг бууруулах замаар ажилтнуудыг мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрийн ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэх олон улсын жишигт нийцсэн арга, технологийг эзэмшсэн, хүнлэг энэрэнгүй, ёс зүйтэй, мэргэжлийн өндөр ур чадвартай, МУ-д мөрддөг хууль, тогтоомжийн хүрээнд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тусламж үйлчилгээг ажилтнуудад хүргэх цогц чадамжтай **Хөдөлмөрийн эрүүл ахуйч-аюулгүй байдлын ажилтан** мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Хөтөлбөрөөр бэлтгэгдсэн мэргэжилтэн нь үйлдвэр, аж ахуйн нэгж, МХЕГ, ХАБЭМТ, их дээд сургууль, ХАБЭА-н сургалтын төвүүдэд, судалгааны байгууллагуудад Хөдөлмөрийн эрүүл ахуйч, Хөдөлмөрийн эрүүл ахуйч- аюулгүй байдлын ажилтан, Хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтны ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангана.